

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠬᠠᠵᠠᠷ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2026/001/НА-СТА-ТЕЗ

## Агуулга

Тайлан бэлтгэсэн:

Сүхбаатар аймаг  
дахь Төрийн аудитын  
газрын дарга,  
тэргүүлэх аудитор:  
Г.Даваа

Аудитын менежер:  
М.Нарантуяа

Ахлах аудитор:  
Ө.Золзаяа

Аудитор:  
Б.Мөнхбамбар

2026 оны 4 дүгээр  
сар

Уг тайланг УАГ-ын  
Цахим хуудаснаас  
үзнэ үү.

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Нутгийн  
удирдлагын 2 дугаар  
байр, Балдан-  
Осорын гудамж, 7  
дугаар баг, Баруун-  
Урт сум, Сүхбаатар  
аймаг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	2
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	2
1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ...	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. АУДИТЫН ТАЙЛАН .....	11
3.1 Байгууллагын талаарх мэдээлэл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй 11	
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт .....	12
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	13
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	13
4.2 Авлага .....	16
4.3 Бараа материал .....	17
4.4 Урьдчилгаа .....	18
4.5 Үндсэн хөрөнгө .....	19
4.6 Өр төлбөр .....	21
4.7 Засгийн газрын хувь оролцоо .....	22
4.8 Орлогын данс .....	22
4.9 Зардал .....	23
4.10 Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил, залруулга .....	25
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	31
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	31
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ .....	32

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдврийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт №2	Авлагын үлдэгдэл
Хүснэгт №3	Бараа материалын үлдэгдэл
Хүснэгт №4	Урьдчилгаа дансны үлдэгдэл
Хүснэгт № 5	Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт № 6	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт № 7	Нийт өр төлбөрийн үлдэгдэл
Хүснэгт № 8	Засгийн газрын оролцоо
Хүснэгт №9	Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт№10	Зардлын бүртгэл
Хүснэгт№11	Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байгууллага
Хүснэгт№12	Төсвийн шууд захирагчийн зөрчлийн судалгаа
Хүснэгт№13	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн судалгаа
Хүснэгт№14	ОНӨААТҮГ-ын зөрчлийн судалгаа
Хүснэгт № 15	Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

# 1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.04.20 № 274

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Бид санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулгад тусгасан Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд анхаарал хандуулж байна. ОНХС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант оны эцэст 13,002.9 сая төгрөг болж, өмнөх оноос 6,154.0 сая төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн байна.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэл, хөрөнгө, авлага, өр төлбөрийн бүртгэл, тайлагнал нь аудитын явцад хамгийн их мэргэжлийн анхаарал шаардсан асуудал байсан. Тус тайланд нийт 100 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтын зардлын ангилал, хөрөнгө, авлага, өр төлбөрийн

бүртгэл, тооцоо нийлэлттэй холбоотой материаллаг дүн бүхий алдаа, зөрчил илэрсэн. Бид уг асуудлын хүрээнд холбогдох тайлан, анхан шатны баримт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тулган шалгаж, шаардлагатай залруулгыг тусгуулсан бөгөөд уг асуудлаар тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хүрээнд хамаарахгүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		59,745,716.57	60,118,241.37
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	31,469,365.11	30,051,019.79
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	4,110,676.55	4,999,874.13
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	154,711.49	78,512.47
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	3,738,631.98	4,177,179.6
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	108,511.8	204,151.25
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	20,163,819.64	20,607,504.12
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		75,354,204.32	96,573,829.8
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	75,354,204.32	96,573,829.8
10	1.2.2.02 Биет хөрөнгө		66,420,374.82	86,849,171.43
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	8,905,079.5	9,695,758.37
12	1.2.2.04 Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	28,750	28,900
13	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		135,099,920.89	156,692,071.16
14	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		36,228,767.31	51,232,710.01
15	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		23,646,967.53	37,925,580.17
16	2.1.1.02 Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	642,162.09	1,124,125.91
17	2.1.1.03 Өглөг		1,394,660.46	6,680,516.75
18	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	21,610,144.98	30,120,937.51
19	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,581,799.77	13,307,129.83
20	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	12,581,799.77	13,307,129.83
21	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		98,871,153.59	105,459,361.16
22	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		98,871,153.59	105,459,361.16
23	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		34,647,339.17	34,630,744.29
24	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		4,945,071.57	5,203,469.45
25	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		236,955.96	236,955.96
26	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		48,968,887.28	55,315,291.85
27	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		10,072,899.61	10,072,899.61
28	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		135,099,920.89	156,692,071.16

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
---	-------------------	-----------	------------------------	------------------------

1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		102,043,764.46	102,610,835.18
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		37,576,804.09	44,142,406.81
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		29,830,480.82	35,745,464.01
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		21,007,415.89	23,276,778.15
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-761,158.95	-993,522.92
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		9,584,223.88	13,462,208.78
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		2,480,364.75	3,288,681.86
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		5,265,958.52	5,108,260.93
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	61,756,594.65	58,468,428.37
10	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого		102,088.17	243,792.28
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		3,620	1,082,205.09
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,710,365.73	0.0
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	70,013,981.84	74,051,720.69
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		69,978,259.96	74,050,527.36
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		66,058,195.01	71,109,561.12
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		17,561,783.81	21,139,148.32
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,136,307.64	4,621,089.1
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,023,693.08	12,132,452.51
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		1,576,028.17	1,459,246.36
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		18,145.86	247,478.41
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		1,572,654.2	1,587,920.11
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		467,898.13	459,281.96
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		14,969,944.57	16,169,275.89
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		18,731,739.55	13,293,668.48
25	1.1.2.01.3 ТАТААС		1,429,232.8	940,406.18
26	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,490,832.15	2,000,560.06
27	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		35,721.87	1,193.33
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		32,029,782.62	28,559,114.49
29	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		29,318.17	106,181.82
30	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		19,989,325.58	36,808,724.93
31	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-19,960,007.42	-36,702,543.11
32	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		12,069,775.21	-8,143,428.62

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,721,152.22	86,721,152.22
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	39,750.16	39,750.16
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,760,902.38	86,760,902.38

4	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	35,122	35,122
5	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	5,354	5,354
6	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	12,069,775.21	12,069,775.21
7	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,871,153.59	98,871,153.59
8	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	98,871,153.59	98,871,153.59
9	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	14,489,833.19	14,489,833.19
10	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,360,986.78	113,360,986.78
11	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	191,803	191,803
12	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	50,000	50,000
13	1.7 Тайлант үеийн үр дүн	-8,143,428.62	-8,143,428.62
14	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	105,459,361.16	105,459,361.16

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	104,605,176.62	108,117,464.82
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	37,579,108.9	44,125,163.04
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	29,833,010.63	35,684,466.25
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-761,158.95	-993,522.92
5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	9,584,223.88	13,462,208.78
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	2,480,364.75	3,288,681.86
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	5,265,733.52	5,152,014.93
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	649,759.82	1,767,896.67
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	2,657,668.45	1,657,332.99
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,958,305.24	1,726,785.27
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,247,308.09	63,992,301.77
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	32,712,221.83	33,723,676.07
13	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	102,088.17	243,792.28
14	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,141,822.13
15	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	31,432,998.1	28,883,011.3
16	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,778,759.63	0.0
17	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,648,619	77,549,365.15
18	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	74,648,619	77,549,365.15
19	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,700,337.14	74,610,500.46
20	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,286,110.44	29,342,683.64
21	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,052,944.62	4,882,841.83
22	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,365,582.99	13,395,500.01
23	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	6,965,514.23	6,146,910.36
24	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	31,909.4	253,239.59
25	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,616,438.02	1,531,831.47

26	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	453,955.73	382,721.92
27	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,955,605.6	7,858,664.07
28	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	12,972,276.1	10,816,107.58
29	1.1.1.2.01.3 ТАТААС	1,446,992.8	940,000
30	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,501,289.06	1,998,864.69
31	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,956,557.61	30,568,099.66
32	1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	12,084.27	21,761.01
33	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	22,706,564.76	31,899,882.67
34	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,706,564.76	31,899,882.67
35	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	22,706,564.76	31,899,882.67
36	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-22,694,480.49	-31,878,121.66
37	1.1.3.1 Бусад эх үүсвэр	1,576.27	658,549.25
38	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	500,355.81	710,035
39	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	25,360.54	56,837.57
40	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-524,140.09	-108,323.32
41	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,737,937.04	-1,418,345.32
42	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,731,428.07	31,469,365.11
43	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,469,365.11	30,051,019.79

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	88,709,724.8	86,171,041.4	2,538,683.4	97
11	Татварын орлого	45,250,026.8	44,129,513.4	1,120,513.4	98
110	Орлогын албан татвар	35,088,819.2	35,688,816.6	(599,997.4)	102
1100	Хувь хүний орлогын албан татвар	22,182,342.1	23,220,130.8	(1,037,788.7)	105
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	18,720,178.1	19,780,053.7	(1,059,875.6)	106
110002	Үйл ажиллагааны орлого	808,848.0	1,109,414.5	(300,566.5)	137
110003	Хөрөнгийн орлого	2,021,258.4	1,440,881.0	580,377.4	71
110004	Хөрөнгө борлуулсны орлого	319,900.0	420,270.1	(100,370.1)	131
110008	Шууд бус орлого	312,157.6	469,511.4	(157,353.8)	150
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(993,522.9)	(993,522.9)	0.0	100
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(993,522.9)	(993,522.9)	0.0	100
1103	ААН-ын орлогын албан татвар	13,900,000.0	13,462,208.8	437,791.2	97
110301	ААН-ын орлогын албан татвар	13,900,000.0	13,462,208.8	437,791.2	97
113	Хөрөнгийн албан татвар	2,922,687.1	3,288,681.9	(365,994.8)	113
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	949,910.2	1,769,584.1	(819,673.9)	186

113002	Бууны албан татвар	30,460.0	30,730.5	(270.5)	101
113003	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,121,400.0	911,065.4	210,334.6	81
113004	Малд ногдуулах албан татвар	820,916.9	577,301.9	243,615.0	70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,238,520.5	5,152,014.9	2,086,505.6	71
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,453,932.0	1,767,896.7	(313,964.7)	122
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,106,700.0	1,560,089.6	(453,389.6)	141
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	16,200.0	12,750.0	3,450.0	79
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	331,032.0	195,057.1	135,974.9	59
1181	Газрын төлбөр	3,953,360.1	1,657,333.0	2,296,027.1	42
118101	Газрын төлбөр	452,951.0	696,102.1	(243,151.1)	154
118102	Дуудлага худалдаа	3,500,409.1	961,230.9	2,539,178.2	27
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,794,228.4	1,726,785.3	67,443.1	96
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	669,760.0	462,331.6	207,428.4	69
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,116,350.0	1,230,807.7	(114,457.7)	110
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	8,118.4	33,646.0	(25,527.6)	414
1183	Бусад татвар	37,000.0	-	37,000.0	-
118301	Бусад татвар	37,000.0	-	37,000.0	-
12	Татварын бус орлого	43,459,698.0	42,041,527.9	1,418,170.1	97
120	Нийтлэг татварын бус орлого	14,300,263.2	12,914,724.3	1,385,538.9	90
120001	Хувьцааны ногдол ашиг	282,700.0	31,231.3	251,468.7	11
120003	Торгуулийн орлого	2,793,605.0	2,899,814.5	(106,209.5)	104
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	833,849.9	789,191.7	44,658.2	95
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	2,530,438.5	2,679,814.5	(149,376.0)	106
120009	Бусад орлого	7,859,669.8	6,514,672.3	1,344,997.5	83
121	Хөрөнгийн орлого	100,000.0	243,792.3	(143,792.3)	244
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	100,000.0	243,792.3	(143,792.3)	244
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	29,059,434.8	28,883,011.3	176,423.5	99
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	19,709,489.5	19,533,066.0	176,423.5	99
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	9,349,945.3	9,349,945.3	-	100
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,461,099.9	83,029,463.3	26,431,636.6	76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,405,135.1	53,372,636.3	8,032,498.8	87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,662,374.0	50,153,777.5	7,508,596.5	87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,557,950.1	19,308,942.3	1,249,007.8	94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,555,360.9	2,367,538.8	187,822.1	93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,060,873.9	11,483,978.7	576,895.2	95
2104	Хангамж, бараа материалын зардал	1,005,478.7	765,459.6	240,019.1	76
2105	Нормативт зардал	245,450.0	236,214.2	9,235.8	96

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,711,756.2	1,532,469.8	179,286.4	90
2107	Томилолт, зочны зардал	483,648.4	356,030.3	127,618.1	74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,683,641.6	6,801,606.3	882,035.3	89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,358,214.2	7,301,537.5	4,056,676.7	64
212	ТАТААС	1,302,568.5	1,260,000.0	42,568.5	97
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	232,568.5	200,000.0	32,568.5	86
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,070,000.0	1,060,000.0	10,000.0	99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,440,192.6	1,958,858.8	481,333.8	80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	800,378.8	733,559.1	66,819.7	92
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,639,813.8	1,225,299.7	414,514.1	75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,259,783.8	28,946,792.0	15,312,991.8	65
220001	Барилга байгууламж	6,760,709.3	3,716,338.0	3,044,371.3	55
221001	Их засвар	8,576,768.5	6,844,139.6	1,732,628.9	80
222001	Тоног төхөөрөмж	5,123,093.5	3,291,885.7	1,831,207.8	64
223001	Бусад хөрөнгө	23,799,212.5	15,094,428.7	8,704,783.8	63
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,796,181.0	710,035.0	3,086,146.0	19
230001	Эргэж төлөгдөх зээл	3,796,181.0	710,035.0	3,086,146.0	19
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(20,751,375.1)	3,141,578.1	(23,892,953.2)	(15)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,751,375.1	(3,141,578.1)	23,892,953.2	(15)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	20,751,375.1	(3,141,578.1)	23,892,953.2	(15)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	21,595,456.3	(21,595,456.3)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	24,737,034.3	(24,737,034.3)	

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	ТЕЗ цэвэр дүн
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,291,685.80</b>
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,291,685.80
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	107,965.50
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	303,053.50
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	145,741.40
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	734,925.50
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>825,150.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>825,150.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>796,938.20</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,779.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,569.30

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,843.90
2104	Хангамж, бараа материалын зардал	62,250.30
2105	Нормативт зардал	297.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,121.20
2107	Томилолт, зочны зардал	12,830.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	202,540.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	402,705.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,212.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,212.40
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>466,535.10</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(466,535.10)</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(466,535.10)</b>

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 Байгууллагын талаарх мэдээлэл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Аудитын үйл ажиллагаа нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоонд хийсэн үнэлгээнд үндэслэн гүйцэтгэсэн бөгөөд аудитын явцад илэрсэн зөрчил, алдаа, анхаарал хандуулах шаардлагатай асуудлууд, тэдгээрт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдэл, аудитын санал дүгнэлтийн агуулга, үндэслэлийг хураангуйлан тусгав.

Төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, ашиглалт, хадгалалтад хяналт тавих чиглэлээр өгсөн зөвлөмж, саналуудыг “Менежментийн захидал”-д багтаан хүргүүлсэн болно.

Аудитын шалгалтыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ээс 20-ны өдрүүдэд зохион байгуулж, аудитын тайланг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулсан бөгөөд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын байгууллагад 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/395 тоот албан бичгээр ирүүлснийг үндэслэн боловсруулав.

Тус аудитын үйл ажиллагааг ахлах аудитор Ө.Золзаяа, аудитор Б.Мөнхбамбар, О.Барчидгүнсэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Нарантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа нар хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Засаг дарга нь “Мэдлэгт суурилсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тээвэр логистикийн хөгжлийн тулгуур төв болох” эрхэм зорилго дэвшүүлж, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг 8 зорилт 124 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг хангасан байна.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 сарын 03-ны өдрийн 46 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хэлэлцэж нийт төлөөлөгчдийн 96.2 хувийн саналаар "Хангалттай" гэж үнэлсэн.

Аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 14 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.4.5, 8.4.7, 8.4.8, 8.10.4, 12 дугаар зүйлийн 12.1.9, 14 дүгээр зүйлийн 14.1.8, 14.1.9, 14.1.10 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.6, 57 дугаар зүйлийн 57.2, 70 дугаар зүйлийн 70.5 дахь хэсэгтэй хамааралтай байна.
- Хөдөлмөрийн тухай тухай хуульд 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэг төсвийн байгууллагуудад хамааралтай байна.
- Татварын ерөнхий хуульд 8 удаа өөрчлөлт оруулснаас 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6, 13.7 дахь хэсэгт өөрчлөлт орсон.
- Сангийн сайдын 2025.01.09-ний А/3 тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-д өөрчлөлт оруулж, **Санхүүгийн тайлангийн шинэ маягт, дансны жишиг жагсаалт, тодруулгын зааврыг** шинэчлэн баталсан
- Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,067.3 сая төгрөг буюу 58.3 хувиар бууруулан 9,349.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт хуваарилах орлогын шилжүүлгийг 6,853.2 сая төгрөг буюу 25.8 хувиар бууруулан 19,709.5 сая төгрөгөөр тус тус бууруулж баталжээ.

Мөн Засгийн газрын тогтоол, салбарын сайдын баталсан журам зааврын шинэчлэл, өөрчлөлтийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө төлөвлөлтөөс зөрүүгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын харьяа төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын нийт 29 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, 75 объектын үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн байна.

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2025 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, удирдамжаар нийт 87 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар нийт 1,749.2 сая төгрөгийн зөрчил илрүүлжээ. Илэрсэн алдаа, зөрчлийн 7 хувь буюу 122.3 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, 93 хувь буюу 1,626.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж

шийдвэрлэснээс төлбөрийн акт 81.2 хувь, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 96.3 хувь буюу бүрэн биелсэн байна.

### 3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг аймгийн Засаг даргын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 70,014.0 сая төгрөгийн 1.5 хувь буюу 1,050.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь болох 787.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Тайлант оны мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 31,469.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 30,051.0 сая төгрөг болж өмнөхөөс 1,418.3 сая төгрөг буюу 4.5 хувиар буурчээ.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх Хувь
Касст байгаа бэлэн мөнгө	1.05	4.43	3.38	0.01
Банканд байгаа бэлэн мөнгө	31,468.32	30,046.59	(1,421.73)	99
<b>Дүн</b>	<b>31,469.37</b>	<b>30,051.02</b>	<b>(1,418.35)</b>	<b>100</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага	9,705.60	4,679.23	(5,026.37)	16
Төсөл/ сан	8,747.10	15,948.42	7,201.32	53
Төрийн сан	12,374.80	8,750.38	(3,624.42)	29
ОНӨҮГ	641.80	673.00	31.20	2
<b>Дүн</b>	<b>31,469.30</b>	<b>30,051.03</b>	<b>(1,418.27)</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,418.3 сая төгрөгөөр буурахад төсөвт байгууллагын үлдэгдэл 5,026.37 сая төгрөгөөр, төрийн сангийн үлдэгдэл 3,624.4 сая төгрөгөөр тус тус буурч, төсөл сангийн үлдэгдэл 7,201.3 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үлдэгдэл 31.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлжээ.

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдлийн 4,679.2 сая төгрөг буюу 16 хувийг төсөвт байгууллага, 15,948.4 сая төгрөг буюу 53 хувийг төсөл сан, 673.0 сая төгрөг

буюу 2 хувийг орон нутгийн өмчит байгууллага, 8,750.4 сая төгрөг буюу 29 хувийг төрийн сангийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах хөрөнгийн үлдэгдэл байна.

- **Ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл:** Ерөнхий орлогын дансны үлдэгдэл өмнөх оноос 3,624.4 сая төгрөгөөр буурч 8,750.4 сая төгрөг болжээ.

**Тайлант оны эцэст**

Орон нутгийн ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос **29.3 хувиар буурсан** нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, нүүрсний үнийн уналт, төсвийн орлогын тасалдал, инфляцын дарамт зэрэг голлох хүчин зүйлсийн нөлөөгөөр 2025 оны сүүлээр мэдэгдэхүйц хүндрэлтэй тулгарсантай холбоотой байна.



*Тухайлбал*, аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг **13,067.3 сая төгрөгөөр буюу 58 хувиар бууруулж**, аймгийн төсөвт тодотгол хийсэн байна. Мөн аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг **3,193.0 сая төгрөгөөр бууруулан** баталснаас аймаг, сумдын ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг санхүүжилт дутагдалтай арга хэмжээнүүдэд хуваарилахад хүрсэн байна.

Харин **Асгат, Сүхбаатар, Түмэнцогт, Уулбаян, Эрдэнэцагаан** сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл **5,571.2 сая төгрөгт хүрч**, нийт үлдэгдлийн **64 хувийг** эзэлж байна. Дээрх сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл өссөн нь **гадаад ажиллах хүчний квотын төлбөр, ан амьтны нөөц ашигласны хураамж (идлэг шонхор шувуу), газрын дуудлага худалдааны орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар** зэрэг зарим нэр төрлийн орлого **давж биелсэн**, мөн **төлөвлөгдөөгүй орлого төвлөрсөн** зэрэг нийтлэг шалтгаантай байна. *Тухайлбал*: Тайлант онд Эрдэнэцагаан, Уулбаян, Түмэнцогт сумдад ан амьтны нөөц ашигласны төлбөр нийт 231.6 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого төвлөрсөн, Асгат сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компани Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан ажлын байрны төлбөр (гадаад ажилтны ажиллах хүчний квот) 1,551.9 сая төгрөгийг тайлант оны эцэст шилжүүлсэн, Сүхбаатар сумын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 655.2 сая төгрөгөөр давж биелсэнд Цайрт минерал ХХК-ийн далд уурхайн үл хөдлөх хөрөнгө ашиглалтад орсон нь нөлөөлсөн байна.

- **Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл:** Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,002.9 сая төгрөг болж өмнөх оноос 6,154.0 сая төгрөг буюу 1.9 дахин өссөн байна. Энэ нь төсөл арга хэмжээ нь холбогдох баримт бичиг дутуугаас худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тендер зарласан боловч амжилтгүй болсон, бүрэн хэрэгжээгүй, техникийн тодорхойлолтод заасан шалгуур, нөхцөлд нийцээгүй, гэрээг дүгнэж, улсын комисс хүлээж аваагүй нь ОНХС-ийн дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

- **Хоршоо хөгжүүлэн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл:** Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 40.1 сая төгрөгөөр буюу 2 хувиар өсөж 1,905.2 сая төгрөг болсон байна. Наран, Түмэнцогт, Асгат, Уулбаян, Баруун-Урт,

Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл өмнөх оноос өссөн боловч бусад сумдын үлдэгдэл 20-84 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Наран, Түмэнцогт, Уулбаян, Мөнххаан, Эрдэнэцагаан сумын ХХС-аас 995.2 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй байна. Дээрх сумд хоршоо хөгжүүлэх сангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдах төсөл, арга хэмжээг шалгаруулах зар мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж, сургалт сурталчилгаа явуулсан боловч Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар баталсан **“Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”**-ын шаардлагад нийцэхгүй байх хүндрэл үүссэн байна.

- **Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл:** ОНӨҮГ-уудын мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 31.2 сая төгрөгөөр өсөж 673.0 сая төгрөг болжээ. Үүнээс Сүхбаатар хөгжил ҮТП, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ, Уртын гэгээ, Дөрвөлж, Сүхбаатар соёл амралтын хүрээлэн, Сүхбаатар тохижилт үйлчилгээ, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги, Чоногол тохижилт ОНӨҮГ-ын мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 624.5 сая төгрөг буюу нийт үлдэгдлийн 93 хувийг эзэлж байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 2,334.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 309.8 сая төгрөгийн алдааг залруулж, 145.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 56.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох санал, 1,690.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 132.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүллээ. Үүнд: Зөрчлийг байгууллагаар ангилж харуулбал:

- *Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 1,530.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Асгат, Сүхбаатар сумын Засаг дарга, 13 сумын ОНХС, Халзан сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ/*
- *Албан хаагчийг үндэслэлгүй халсан, чөлөөлсөн асуудлыг Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд төсвийн захирагч ажилд эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр 3.5 сая төгрөгийг буцаан төлүүлээгүй. /Дарьганга сумын ИТХ/*
- *Хууль, эрх зүйн болон дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгэсний төлөө 17.3 сая төгрөгийн нэмэгдэл авсан. /Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Сүхбаатар, Түвшинширээ, Халзан, Эрдэнэцагаан сумын ЗДТГ/*
- *Хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар 16.5 сая төгрөгийн тэтгэмж олгосон. /Асгат, Сүхбаатар сумын ЗДТГ/*
- *Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны хөнгөлөлтийг 0.9 сая төгрөгөөр давхар олгосон. /Баяндэлгэр, Түвшинширээ сумын ЗДТГ/*
- *Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан 264.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Дарьганга сумын ИТХ, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумын ЗДТГ, Эрдэнэцагаан сумын ОНХСан/*
- *Иргэн хоршооны нэрээр зээл авсан, зээлээ зориулалтын дагуу зарцуулаагүй 100.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Түвшинширээ сумын ХХСан/*
- *Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 0.6 сая төгрөгийн ажил гүйлгээ хийгдсэн. /аймгийн ЗДТГ/*
- *Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хоорондоо зөрүүтэй тайлгасан бөгөөд албан хаагчдын цалин хөлсний мэдээллийг 21.2 сая төгрөгөөр буруу мэдээлсэн. /Эрдэнэцагаан сумын ЗДТГ/*
- *Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд үндэслэл тодорхойгүйгээр хавтгайруулан 24 албан хаагчид 69.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон. /Сүхбаатар сумын эрүүл мэнд боловсролын сан/*

*Тайлант онд илэрсэн зөрчлүүд нь төсвийн сахилга хариуцлага, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж, санхүүгийн удирдлага, хяналтын тогтолцоонд системийн түвшний доголдол байгааг харуулж байна. Анхан шатны баримтын иж бүрдлийг хангалтгүй гүйлгээ бүртгэсэн нь санхүүгийн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж байна. Үүнээс гадна, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулах нөхцөлийг алдагдуулсан байна.*

## 4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 4,110.6 сая төгрөг байсан бол тайлант оны эцэст 5,026.6 сая төгрөг болж, 916.0 сая төгрөг буюу 22 хувиар өссөн байна.

### Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/ сая төгрөг/


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.6	15.0	12.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	286.0	316.8	30.8
Татаас, санхүүжилтийн авлага	0.4	-	(0.4)
Зээлийн хүүгийн авлага	36.9	37.6	0.7
Дансны авлага /ТӨҮГ/	1,048.9	1,640.7	591.8
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	20.8	20.7	(0.1)
Бусад авлага	2,605.4	2,555.7	(49.7)
Зээлийн авлага	109.6	413.3	303.7
<b>Дүн</b>	<b>4,110.6</b>	<b>4,999.9</b>	<b>889.3</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	352.2	904.6	552.4
Төрийн сан	210.3	21.8	(188.5)
ОНӨҮГ	1,151.7	1,661.9	510.2
Төсөл сан	2,396.4	2,411.6	15.2
<b>Дүн</b>	<b>4,110.6</b>	<b>4,999.9</b>	<b>889.3</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлээс бусад авлага 2,555.7 сая төгрөг буюу 51.1 хувийг, дансны авлага /ОНӨҮГ/ 1,640.7 сая төгрөг буюу 32.8 хувийг, зээлийн авлага 413.3 сая төгрөг буюу 8.3 хувийг, төлбөртэй үйлчилгээний авлага 316.8 сая төгрөг буюу 6.3 хувийг, зээлийн хүүгийн авлага 37.6 сая төгрөг буюу 0.8 хувийг, татвар, НДШ-ийн авлага 20.7 сая төгрөг буюу 0.4 хувийг, ажиллагсадтай холбогдсон авлага 15.0 сая төгрөг буюу 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд дансны авлага 591.8 сая төгрөгөөр, зээлийн авлага 303.7 сая төгрөгөөр, төлбөртэй үйлчилгээний авлага 30.8 сая төгрөгөөр, ажиллагчидтай холбогдсон авлага 12.4 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 0.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн ба бусад авлага 49.7 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт авлагын 18 хувь буюу 904.6 сая төгрөг төсөвт байгууллага, 33 хувь буюу 1,661.9 сая төгрөг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 1 хувь буюу 21.8 сая төгрөг төрийн сан, 48 хувь буюу 2,411.6 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх болон орон нутгийн хөгжлийн сангийн авлага эзэлж байна.



### Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад 7.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Илэрсэн алдаа зөрчлийг ангилан авч үзвэл:

- Төсвийн зарцуулагдаагүй үлдээдлийг төсөвт төвлөрүүлээгүй 7.2 сая төгрөгийн бодит бус авлага үүсгэсэн. /Мөнххаан, Сүхбаатар сумын ЗДТГ/

### 4.3 Бараа материал

Бараа материал үлдэгдэл 4,381.3 сая төгрөг болж, өмнөх оноос 534.2 сая төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна.

*Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Түүхий эд материал	114.4	114.4	-	2.6
Дуусаагүй үйлдвэрлэл	172.5	167.5	(5.0)	3.8
Бэлэн бүтээгдэхүүн	27.6	10.6	(17.0)	0.2
Хангамжийн материал	3,020.9	3,549.3	528.4	81.0
Биологийн хөрөнгө	200.8	200.8	(0.0)	4.6
Мал амьтад	202.4	134.6	(67.8)	3.1
Нөөцийн бараа	108.5	204.2	95.7	4.7
<b>Дүн</b>	<b>3,847.1</b>	<b>4,381.3</b>	<b>534.2</b>	<b>100.0</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага	2,840.4	3,192.6	352.2	72.9
ОНӨҮГ	1,006.8	1,188.7	181.9	27.1
<b>Дүн</b>	<b>3,847.1</b>	<b>4,381.3</b>	<b>534.2</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал дансны 1,188.7 сая төгрөг буюу 27.1 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3,192.6 сая төгрөг буюу 72.9 хувийг төсөвт байгууллагын хөрөнгө тус тус эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл 534.2 сая төгрөгөөр өсөхөд хангамжийн материал 528.4 сая, нөөцийн бараа 95.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Хангамжийн материалын өсөлтөд аж ахуйн материал 389.4 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 214.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлжээ.

Тайлант онд худалдан авсан 8,417.1 сая, үнэ төлбөргүй буюу хандив, тусламжаар 351.4 сая, бусад 654.0 сая, нийт 9,422.5 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 8,736.3 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 10.1 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, бусад 141.9 сая нийт 8,888.3 сая төгрөгийн бараа материал зарцуулагдсан байна.

### Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой нийт 910.0 сая төгрөгийн илрүүлэлтээс 629.6 сая төгрөгийн алдааг залруулж, 141.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх 139.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлжээ. Үүнд:

- 2024 оны зудад үрэгдсэн 48.3 сая төгрөгийн малыг данснаас хасаж, тодруулаагүй. /Сүхбаатар сумын ЗДТГ/
- Тайлант хугацаанд бараа материал хариуцсан нярав томилогдоогүйгээс байгууллагын нягтлан бодогч 120.7 сая төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайланг өөрөө гаргаж, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, тайлагнасан байна. /Сүхбаатар-Ойжуулалт сум дундын ойн анги ОНӨААТҮГ/
- Бараа материалын тайланг анхан шатын баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн, алдаатай тайлагнасан зэрэг 111.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Сүхбаатар нийтлэг үйлчилгээ, Сүхбаатар-ойжуулалт сум дундын анги, Хайлааст голомт ОНӨААТҮГ/

Бараа материалын бүртгэл, зарцуулалттай холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодит байдал алдагдаж, зарим хөрөнгийн ашиглалт, хяналт хангалтгүй хэрэгжсэн байна. Анхан шатны баримтгүйгээр материалыг зарлага болгосон нь дотоод хяналтын сул талыг илтгэж, тайлангийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэжээ.

### 4.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 78.5 сая төгрөг болж, өмнөх оноос 76.2 сая төгрөгөөр буурсан байна.

#### *Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	149.2	78.5	-70.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	5.5	-	-5.5
<b>Дүн</b>	<b>154.7</b>	<b>78.5</b>	<b>-76.2</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
ОНӨҮГ	154.7	78.5	-76.2
<b>Дүн</b>	<b>154.7</b>	<b>78.5</b>	<b>-76.2</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урьдчилгаа дансны үлдэгдэлд Дөрвөлж ОНӨҮГ 77.0 сая төгрөг, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨҮГ 1.4 сая төгрөг, Хайлааст голомт 0.1 сая төгрөгийн урьдчилгаа бүртгэсэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурахад Дөрвөлж ОНӨҮГ-ын 139.7 сая төгрөгийн шугам сүлжээний ажлыг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

#### 4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 20,607.5 сая төгрөг болж, өмнөх оноос 443.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	ДҮНД эзлэх хувь
Төсөвт байгууллага	2,784.9	59.8	(2,725.1)	0.3
Төсөл/ сан	17,378.9	20,547.7	3,168.8	99.7
<b>Дүн</b>	<b>20,163.8</b>	<b>20,607.5</b>	<b>443.7</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*  
Төсөл, сангийн бусад эргэлтийн хөрөнгө 3,168.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гэрээний үүргийн биелэлт хангагдах хүртэл олгосон санхүүжилт болон ТЭЗҮ, зураг төслийн зөвлөх үйлчилгээний зардлуудыг эргэлтийн хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

#### 4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 75,354,2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 96,573.8 сая төгрөг болж, 21,219.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	54,055.8	67,766.0	13,710.2
Хуримтлагдсан элэгдэл	(16,786.8)	(18,331.3)	(1,544.5)
Тээврийн хэрэгсэл	12,530.1	13,566.1	1,036.0
Хуримтлагдсан элэгдэл	(5,954.8)	(5,425.4)	529.4
Машин тоног төхөөрөмж	14,545.3	18,308.9	3,763.6
Хуримтлагдсан элэгдэл	(8,854.1)	(8,714.3)	139.7
Тавилга эд хогшил	2,869.8	3,505.0	635.2
Хуримтлагдсан элэгдэл	(1,609.1)	(1,515.8)	93.3
Зам гүүрийн байгууламж	781.8	781.8	-
Хуримтлагдсан элэгдэл	(221.2)	(285.5)	(64.3)
Дуусаагүй барилга байгууламж	822.0	822.0	-
Номын фонд	0.4	0.2	(0.2)
Бусад үндсэн хөрөнгө	26,305.9	32,011.6	5,705.7
Хуримтлагдсан элэгдэл	(12,064.8)	(15,640.3)	(3,575.5)
Программ хангамж	217.4	402.0	184.6
Хуримтлагдсан элэгдэл	(66.6)	(125.9)	(59.3)
Бусад биет бус хөрөнгө	8,767.1	9,435.7	668.6
Хуримтлагдсан элэгдэл	(12.8)	(16.0)	(3.2)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	28.8	28.9	0.1

	<b>ДҮН</b>	<b>75,354.2</b>	<b>96,573.8</b>	<b>21,219.6</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				-
Төсөвт байгууллага		35,576.3	49,178.3	13,602.0
ТӨҮГ болон ОНӨҮГ		39,777.9	47,395.5	7,617.6
<b>ДҮН</b>		<b>75,354.2</b>	<b>96,573.8</b>	<b>21,219.6</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны өсөлтөд аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн Баруун-Урт сумын төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын 11,397.1 сая төгрөгийн хөрөнгийг Дөрвөлж ОНӨҮГ-ын бүртгэлд тусгасан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдэл 96,573.8 сая төгрөг байгаагаас 49,178.3 сая төгрөг буюу 51.0 хувийг орон нутгийн төсөвт байгууллагуудын, 47,395.5 сая төгрөг буюу 49.0 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,272.1 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан хандив, тусламжийн хөрөнгө 3,089.1 сая төгрөг, шилжүүлэн авсан хөрөнгө 9,291.3 сая төгрөг, бусад нэмэгдэл 20,604.0 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 2,585.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 36,841.7 сая төгрөгийн өсөлт гарсан байна.

Харин худалдсан хөрөнгө 627.5 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн хөрөнгө 692.4 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн хөрөнгө 2,084.4 сая төгрөг, акталсан хөрөнгө 2,809.6 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 19.0 сая төгрөг, бусад хасагдал 4,904.8 сая төгрөгөөр тус тус буурч, нийт 11,137.7 сая төгрөгийн хасагдал бүртгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн шалтгааныг данс тус бүрээр тодруулж үзэхэд дараах үр дүнг гарсан. Үүнд:

- **Барилга, байгууламж дансны** үлдэгдэл 49,434.8 сая төгрөг болж өмнөх оноос 12,165.7 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд Дөрвөлж ОНӨҮГ 12,520.6 сая, Асгат сумын ЗДТГ 126.8 сая, Мөнххаан сумын ЗДТГ 2,770.8 сая, Сүхбаатар аймгийн ЗДТГ 427.3 сая, Онгон сумын ЗДТГ 420.9 сая, Халзан сумын ЗДТГ 190.0 сая, Сүхбаатар соёл амралтын хүрээлэн ОНӨҮГ 113.8 сая төгрөгийн барилга байгууламж тус тус нэмэгдсэн нь гол нөлөөллийг үзүүлсэн байна.
- **Тээврийн хэрэгсэл данс** өмнөх оноос 1,565.4 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Дөрвөлж ОНӨҮГ 1,062.6 сая, Сүхбаатар аймгийн ЗДТГ 608.0 сая, Сүхбаатар аймгийн ИТХ 292.0 сая, Чоногол тохижилт 234.7 сая, Түвшинширээ сумын ЗДТГ 160.0 сая, Сүхбаатар сумын ЗДТГ 131.3 сая, Мөнххаан сумын ЗДТГ 125.0 сая, Онгон Арвижих ОНӨААТҮГ 100.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл тус тус нэмэгдсэн байна.
- **Бусад хөрөнгө данс** өмнөх оноос 0.2 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт үлдэгдэл 28.9 сая төгрөг болсон. Тус дансанд Түмэнцогт ОНӨҮГ таваарлаг буюу ирээдүйд эдийн засгийн ашиг бий болгох малыг биологийн хөрөнгөөр бүртгэсэн ба тайлант онд нас дэвшилт нь дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлж байна.

## Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 3,601.4 сая төгрөгийн илрүүлэлтээс 290.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 82.3 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,228.5 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

- Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй 3,310.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Баруун-Урт сумын орон нутгийн хөгжлийн сан, Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк, Чоногол хөгжил ОНӨААТҮГ/

## 4.6 Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 23,646.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 37,925.6 сая төгрөг болж, 14,278.7 сая төгрөгөөр өссөн нь ОНӨҮГ-уудын үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг НББОУС-20-т заасны дагуу хойшлогдсон орлого дансанд бүртгэснээс үүссэн байна. Мөн тайлант онд сангийн яамнаас зарим зардлын зарцуулалтын эрхийг хязгаарласан нь байгууллагад төлөх өр төлбөрийн үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

*Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн бүүрсан
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>23,646.9</b>	<b>37,925.6</b>	<b>14,278.7</b>
Богино хугацаат зээлийн өглөг	642.2	1,124.1	481.9
Өглөг	1,394.6	6,680.6	5,286.0
Ажиллагчидтай холбогдсон өглөг	94.4	78.7	(15.7)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3.8	146.5	142.7
Бусад өглөг	1,296.3	6,455.4	5,159.1
Байгууллагад төлөх өглөг	906.7	5,376.6	4,469.9
Хувь хүмүүст төлөх өглөг	91.6	332.2	240.6
Татварын өглөг /ТӨҮГ/	115.2	488.1	372.9
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	27.2	52.3	25.1
Дансны өглөг /ТӨҮГ/	155.5	206.2	50.7
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>21,610.1</b>	<b>30,120.9</b>	<b>8,510.8</b>
Бусад урьдчилж орсон орлого	20,806.3	29,152.6	8,346.3
ТӨҮААГ	803.8	968.3	164.5
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>12,581.8</b>	<b>13,307.1</b>	<b>725.3</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	12,580.3	13,307.1	726.8
<b>Нийт дүн</b>	<b>36,228.7</b>	<b>51,232.7</b>	<b>15,004.0</b>
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>23,646.9</b>	<b>37,925.6</b>	<b>14,278.7</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	665.3	5,347.8	4,682.5
Төрийн сан	148.8	143.1	(5.7)
ТӨҮГ болон ОНӨҮГ	22,832.9	32,434.7	9,601.8
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>12,581.7</b>	<b>13,307.1</b>	<b>725.4</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,342.4	12,846.7	11,504.3
Төсөвт байгууллага	11,239.3	460.4	(10,778.9)

<b>Нийт дүн</b>	<b>36,228.7</b>	<b>51,232.7</b>	<b>15,004.0</b>
-----------------	-----------------	-----------------	-----------------

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 12,581.7 сая төгрөг байсан бол тайлант оны эцэст 13,307.1 сая төгрөг болж, 725.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд Дөрвөлж ОНӨҮГ-ын Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Баруун-Урт сумын халаалт, цэвэр, бохир усны шугамын ажил”-ын урт хугацаат зээлийн үлдэгдэл 1,341.0 сая төгрөг, “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн Баруун-Урт сумын төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын урт хугацаат зээлийн үлдэгдэл 11,505.7 сая төгрөг тус тус хамаарч байна. Мөн тайлант онд долларын ханшийн зөрүүнээс үүссэн 460.4 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэсэн нь үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Өр төлбөртэй холбоотой нийт 1,340.4 сая төгрөгийн илрүүлэлтээс 1,338.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.2 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн. **Залруулагдаагүй алдааг дурдвал:**

- Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 2.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. /Хайлааст голомт ОНӨААТҮГ/

### **4.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 98,871.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 105,628.0 сая төгрөг болж 6,756.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн + Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал	34,647.3	34,630.7	(16.6)
Өмч /ОНӨҮГ/	4,945.1	5,203.5	258.4
Эздийн өмчийн бусад хэсэг	236.9	236.9	-
Хуримтлагдсан үр дүн	48,968.9	55,484.0	6,515.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,072.9	10,072.9	-
<b>Дүн</b>	<b>98,871.1</b>	<b>105,628.0</b>	<b>6,756.9</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос өссөнд хуримтлагдсан үр дүн 6,515.1 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгө 258.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлж байна.

### **4.8 Орлогын данс**

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны орон нутгийн төсвийн татварын орлогыг 45,250.0 сая, татварын бус орлогыг 10,936.0 сая нийт 56,286.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 44,037.1 сая, татварын бус орлого 9,523.3 сая нийт 54,134.4 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Үүнээс татварын орлогын гүйцэтгэл 97 хувь, татварын бус орлого 87 хувь нийт дүнгээр 96 хувийн гүйцэтгэлтэй байна.

<i>Хүснэгт №9 Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>			<i>/сая төгрөгөөр/</i>	
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	/2-1/	/2:1/
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>56,286.0</b>	<b>54,134.4</b>	<b>(2,151.60)</b>	<b>96</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>45,250.0</b>	<b>44,037.1</b>	<b>(1,212.90)</b>	<b>97</b>
Хүн амын орлогын албан татвар	21,188.8	22,134.1	(945.33)	104
ААН-ын орлогын албан татвар	13,900.0	13,462.2	(437.79)	97
Хөрөнгийн албан татвар	2,922.7	3,288.7	(365.99)	113
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	16.2	12.8	(3.42)	79
Улсын тэмдэгтийн хураамж	1,106.7	1,560.1	(453.39)	141
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	331.0	195.1	135.97	59
Газрын төлбөр	3,953.4	1,657.3	2,296.03	42
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,794.2	1,726.8	67.40	96
Бусад татвар	37.0	-	37.00	0
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,936.0</b>	<b>9,523.3</b>	<b>(1,412.60)</b>	<b>87</b>
Хүү, торгуулийн орлого	2,793.6	2,941.2	147.60	105
Бусад орлого	7,859.6	6,517.7	(1,341.90)	83
Хөрөнгө худалдсаны орлого	282.7	64.4	(218.30)	23

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Татварын болон татварын бус орлогоос 10 төрлийн орлого 3,467.8 сая төгрөгөөр давж, 8 төрлийн орлого 5,621.4 сая төгрөгөөр тасарсан байна. **Татварын болон татварын бус орлогын давсан, тасарсан шалтгааныг Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээс үзнэ үү.**

#### **Аудитын илрүүлэлт:**

Орлого данстай холбоотой 52.9 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

- *Зээлийн хүүг тусад нь бүртгэлгүйгээс ҮДТ-ийн орлого 52.9 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн. /Асгат, Баяндэлгэр, Наран, Түмэнцогт, Халзан сумын ХХСан/*

#### **4.9 Зардал**

Тайлант оны зардал 74,051.7 сая төгрөг болж өмнө оноос 4,037.8 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №10 Зардлын гүйцэтгэл</i>		<i>/сая төгрөгөөр/</i>	
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өссөн +, Буурсан -
Бараа, ажил үйлчилгээний зардал	66,058.2	71,109.6	5,051.4
Татаас	1,429.2	940.4	(488.8)
Урсгал шилжүүлэг	2,490.8	2,000.6	(490.2)
Хөрөнгийн зардал	35.7	1.2	(34.5)
<b>Дүн</b>	<b>70,013.9</b>	<b>74,051.8</b>	<b>4,037.9</b>
<b><i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i></b>			

Төсөвт байгууллага	60,458.9	54,509.3	(5,949.6)
Төсөл, сан	473.7	161.7	(312.0)
Төрийн сан	130.5		(130.5)
ТӨҮГ болон ОНӨҮГ	10,928.9	19,380.7	8,451.8
<b>Дүн</b>	<b>70,013.9</b>	<b>74,051.7</b>	<b>4,037.9</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Бараа, ажил үйлчилгээний зардал:** Тухайн зардал тайлант онд 4,037.9 сая төгрөгөөр өссөн байна. Зардал өсөхөд цалин хөлс нэмэгдэл 3,577.4 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,484.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,108.8 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна. Тайлант онд төсвийн байгууллагын дулаан, халаалт, цэвэр бохир усны төлбөрийн тариф болон цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор дээрх зардал өссөн байна.

**Татаас:** Тайлант онд ОНӨААТҮГ-уудад нийт 840.4 сая төгрөг, Ахмадын хороо 50.0 сая, Улаан загалмай Сүхбаатар салбар 50.0 сая, нийт 940.4 сая төгрөгийн татаас санхүүжилт олгосон байна.

**Урсгал шилжүүлэг:** Урсгал шилжүүлэг 2,000.6 сая төгрөг болж, өмнөх оноос 490.2 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2025 оны 07 угаар сарын 29-ний өдрийн хуралдааны 32 тоот тодотголоор санхүүгийн дэмжлэгийг өмнөх оноос 3,192.9 сая төгрөгөөр бууруулж 8,333.5 сая төгрөгөөр баталсан нь нөлөөлжээ.

**Хөрөнгийн зардал:** Хөрөнгийн зардал өмнөх оноос 34.5 сая төгрөгөөр буурч 1.2 сая төгрөгөөр тайлагнасан нь өмнөх онд сумдын авто машины парк шинэчлэлттэй холбоотой бүртгэлүүд нөлөөлсөн байна.

### Аудитын илрүүлэлт:

Зардлын данстай холбоотой нийт 455.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 341.4 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 77.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. **Зөрчлийг авч үзвэл:**

- Цалин, нэмэгдэл, урамшууллыг 63.7 сая төгрөгөөр зөрчилтэй бодож олгосон. /Худалдан авах ажиллагааны газар, Баяндэлгэр, Дарьганга, Түвшинширээ, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын ЗДТГ, Дарьганга сумын ИТХ, Хайлааст голомт ОНӨААТҮГ/
- Анхан шатны баримтыг хуурамч үйлдэж 2.8 сая төгрөг зарцуулсан. /Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумын ЗДТГ/
- Төсвийн хөрөнгөөр тэмцээн зохион байгуулсан, төрийн албан хаагчдын нэгдсэн тэмцээнд оролцоход төсвөөс 33.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. /Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Наран, Онгон, Түвшинширээ, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумын ЗДТГ, Баруун-Урт, Онгон сумын ИТХ/
- Төсвөөс 3.3 сая төгрөг зориулалт бус зарцуулсан /Эрдэнэцагаан сумын ЗДТГ/
- Төсвийн хөрөнгөөр 1.5 сая төгрөгийн архи согтууруулах ундаа худалдан авсан. /Түвшинширээ сумын ЗДТГ/
- Төсвийн хөрөнгөөр 3.5 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. /Эрдэнэцагаан сумын ЗДТГ, Наран Сүхбаатар сумын ИТХ/
- Төсвөөс 5.5 сая төгрөгийн хандив олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. /Мөнххаан, Эрдэнэцагаан сумын ЗДТГ/

*Төрийн болон төсвийн байгууллагууд төрийн албан хаагчдад олгосон цалин, урамшуулал, нөхөн олговрыг зохисгүй зарцуулсан нь санхүүгийн хяналт, хариуцлагын тэнцвэрийг хангаагүй илтгэж байна. Тухайлбал, үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгох, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгох зэрэг нь төсвийн зориулалтыг зөрчиж, зохих журмаар баталгаажуулаагүй зардлууд гарсан.*

*Мөн зориулалтгүй болон үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй зарцуулалт хийсэн нь төсвийн үр ашгийг бууруулж, төрийн санхүүгийн удирдлагад эрсдэл үүсгэж байна.*

*Эдгээр ажил гүйлгээ, илэрсэн асуудлууд нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.*

#### **Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлээр ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 303.1 сая, хандив тусламж 108.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 145.7 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 734.9 сая нийт 1,291.7 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 466.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 96 хувийг урсгал зардал, 4 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна. Тухайлбал нэмэлтийн дансны зарцуулалтыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 58.8 сая
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12.6 сая
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17.8 сая
- Хангамж, бараа материалын зардалд 62.3 сая
- Нормативд зардалд 0.3 сая
- Эд хогшил, урсгал засварын зардалд 27.1 сая
- Томилот, зочны зардалд 12.8 сая
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 202.5 сая
- Бараа үйлчилгээний бусад зардалд 402.7 сая
- Урсгал шилжүүлэг 28.2 сая төгрөг зарцуулсан.

#### **4.10 Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил, залруулга**

##### **Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргав.

**Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 сумын Засаг дарга, 67 төсвийн байгууллага, 20 орон нутгийн өмчит**

**аж ахуйн нэгж, байгууллага нийт 100 санхүүгийн тайлан нэгтгэгдэж аудитад хамрагдсан.**

Аудитад хамрагдсан харьяа байгууллагаас 78 байгууллагыг түүвэрт хамруулж, 22 байгууллагад дүгнэлт хүргүүлжээ. Үүнээс 12 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 10 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

**Хүснэгт № 11 “Өөрчлөлттэй” дүгнэлт өгсөн байгууллага**

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
<b>“ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ”</b>	
Асгат сумын Засаг дарга	Тэмцээн уралдаан зохион байгуулахад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, Засаг даргын орлогчид 6 сарын цалинтай тэнцэх тэтгэмж олгосон, ОНХС-ийн 2 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн баталгаа гаргалгүй санхүүжилт олгосон, төсөвт өртийг хувааж тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн, мөн 2 төсөл, арга хэмжээнд банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон.
Баяндэлгэр сумын Засаг дарга	Тэмцээн, уралдаан болон ой, арга хэмжээний зардалд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, албан хаагчдын цалин хөлс, орон нутгийн нэмэгдлийг давхардуулан илүү олгосон, Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээнд чанарын болон банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон, мөн санхүүжилт шилжүүлэхдээ зохих үндэслэл, дотоод хяналтыг хангаагүй, төсөвт өртийг хувааж тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн.
Дарьганга сумын Засаг дарга	Цалин хөлс, нэмэгдлийг алдаатай тооцоолсон болон хуулиар зөвшөөрөөгүй нэмэгдэл олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, шүүхийн шийдвэртэй холбоотойгоор байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, ГХУС-ийн зардлаас хуулиар зөвшөөрөгдөөгүй зарцуулалт хийсэн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын бус ашигласан, гүйцэтгэлийн баталгаа болон банкны баталгаагүйгээр санхүүжилт олгосон, он дамжсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зардлаар бүртгэж тайлагналд буруу тусгасан.
Мөнххаан сумын Засаг дарга	Тэмцээн уралдаан зохион байгуулахад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэлгүй бодит бус авлага үүсгэсэн, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл авсан, Орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд 1 төсөл, арга хэмжээнд гэрээний дагуу шаардах ёстой чанарын баталгааны барьцаалж үлдээгүй, 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, 3 төсөл, арга хэмжээнд банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон.
Наран сумын Засаг дарга	Тэмцээн, уралдаан болон бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээнд чанарын болон банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон, гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй.
Сүхбаатар сумын Засаг дарга	Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэлгүй бодит бус авлага үүсгэсэн, Засаг даргын орлогчид 6 сарын цалинтай тэнцэх тэтгэмж олгосон, ОНХС-ийн 5 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн баталгаагүйгээр санхүүжилт олгосон, 6 төсөл, төсөвт өртийг хувааж тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн, Эрүүл мэнд, боловсролын сангаас мөнгөн тэтгэмжийг шалгуур, үндэслэл тодорхойгүйгээр олгосон.

Түвшинширээ сумын Засаг дарга	Төсвийн хөрөнгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан, сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд үр дүнгийн урамшуулал олгосон, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл авсан, Тэмцээн уралдаан зохион байгуулахад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ОНХС-аас 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртийг хувааж хэсэгчилсэн худалдан авалт хийсэн, ИТХ-аар батлагдсан төсөвт өртгөөс илүү дүнгээр тендер зарлан, гэрээ байгуулж, төлбөр төлсөн, 3 төсөл, арга хэмжээнд банкны баталгаагүйгээр урьдчилгаа төлбөрийн санхүүжилт олгосон, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосон боловч зээлийн гэрээг хоршооны эрх бүхий албан тушаалтан байгуулаагүй, зээлийн хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, мөн сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийсэн.
Түмэнцогт сумын Засаг дарга	Тэмцээн уралдаан зохион байгуулахад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээнд чанарын болон банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон, мөн санхүүжилт шилжүүлэхдээ зохих үндэслэл, дотоод хяналтыг хангаагүй, тендерийн журмыг зөрчин төсөвт өртгийг хуваан худалдан авалт хийсэн.
Халзан сумын Засаг дарга	Тэмцээн уралдаан зохион байгуулахад төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, төсөвт өртийг хувааж тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн, сумын 100 жилийн ойн баримтад кино хийхэд төсвөөс хөрөнгө зарцуулсан боловч ажлаа хүлээж аваагүй, ОНХС-аас 6 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулахдаа чанарын баталгаа шаардаагүй, 2 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, зураг төсөв магадлалаар баталгаажаагүй байхад санхүүжилт олгосон.
Эрдэнэцагаан сумын Засаг дарга	Тэмцээн, уралдаан болон ой, арга хэмжээний зардалд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын тайланд зөрүү гарган дутуу тайлагнасан, цалингийн урьдчилгаа олгож суутгал хийгдээгүй, Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээнд чанарын болон банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон, санхүүжилт шилжүүлэхдээ зохих үндэслэл, дотоод хяналтыг хангаагүй хэрэгжүүлсэн, мөн тендерийн журмыг зөрчин төсөвт өртгийг хуваан худалдан авалт хийсэн.

**Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 8,700.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,909.3 сая төгрөгийн алдааг залруулж, 228.7 сая төгрөгийн зөрчилд 38 төлбөрийн акт тогтоож, 1,950.4 сая төгрөгийн зөрчилд 89 албан шаардлага, 56.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 3,555.6 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгсөн.**

**Алдаа, зөрчил илэрсэн байдлыг төсвийн захирагч тус бүрээр авч үзвэл:**

**Төсвийн шүүд захирагчийн хувьд:** Орон нутгийн төсвийн 67 байгууллагаас (төсөл, сан орсон дүн) 64 санхүүгийн тайланд үе шатны хяналт хэрэгжүүлсэн бол 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Аудитаар нийт 5,055.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,727.5 сая төгрөгийн 17 алдааг залруулж, 228.1 сая төгрөг зөрчилд 37 төлбөрийн акт тогтоож, 1,809.2 сая төгрөгийн 84 зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн бол 56.8 сая төгрөгийн зөрчил гаргаж, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн

1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 233.4 сая төгрөгийн 10 алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн.

Төсвийн шууд захирагчийн хэмжээнд гарсан алдаа зөрчлийг өмнөх онуудтай харьцуулж үзэхэд алдаа зөрчил 2,115.6 сая төгрөгөөр өссөн байна. Алдаа зөрчлийн нэгтгэлийг харьцуулж харуулав:

Он	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох санал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2021	413	23,853.2	37	9,072.1	53	93.8	91	679.2	226	13,845.4	6	162.7
2022	134	4,550.3	5	122.4	20	58.8	59	4,172.8	48	196.3	2	-
2023	93	5,212.2	24	3,801.7	11	35.8	11	157.8	46	1,216.9	1	-
2024	91	2,939.4	5	322.4	18	56.9	34	1,654.9	31	905.2	3	-
2025	150	5,056.1	17	2,727.7	38	229.0	84	1,809.2	10	233.4	1	56.8

Төсвийн байгууллагын удирдлага, нягтлан бодох бүртгэлийн хариуцлагатай албан тушаалтнуудын бүртгэл, тайлангийн сахилга хариуцлага сул, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал, хууль, журмын хэрэгжилтийг хангах хяналт дутмаг байгаагаас дараах нийтлэг алдаа дутагдал үргэлжилсээр байна. Үүнд: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж тэмцээнд уралдаан зохион байгуулах, бэлэг дурсгалын зүйл худалдан авах, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, урамшуулал олгох, цалин хөлс, урамшуулал илүү олгосон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн зэрэг нь санхүүгийн тайлангийн бодит байдалд сөргөөр нөлөөлж, хууль тогтоомж зөрчих, төсвийн сахилга бат алдагдах, удирдлагын шийдвэр гаргалтад буруу мэдээлэл өгөх эрсдэл бий болгож байна.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд:** Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмж өглөө.

Алдаа зөрчлийн нэгтгэлийг харьцуулж харуулав:

Он	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2021	68	8,305.3	27	8,179.5	3	120.5	6	-	32	5.3
2022	15	603.9	-	-	-	-	2	23.7	13	580.2
2023	35	659.4	7	449.4	-	-	2	195.0	26	15.0
2024	13	-	-	-	-	-	-	-	13	-
2025	17	-	-	-	-	-	1	-	16	-

**Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд:** Аудитаар нийт 3,645.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 181.8 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 141.1 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 3,322.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгөв.

Аймгийн ОНӨААТҮГ-ын хэмжээнд гарсан алдаа зөрчлийг өмнөх онуудтай харьцуулж үзэхэд алдаа зөрчил 2,855.3 сая төгрөгөөр өссөн байна. Алдаа зөрчлийн нэгтгэлийг харьцуулж харуулав:

## Хүснэгт №14 ОНӨААТҮГ-ын зөрчлийн судалгаа

(сая төгрөгөөр)

Он	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох санал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
2021	58	10,741.1	8	131.5	6	3.3	14	1,670.7	30	8,935.6	-
2022	48	2,614.4	7	2,172.3	6	8.2	16	417.3	19	16.6	-
2023	24	758.1	5	614.1	1	0.5	7	113.6	11	29.9	-
2024	21	790.4	2	44.1	3	8.9	6	731.1	7	6.3	3
2025	13	3,645.8	3	181.9	1	0.6	4	141.1	5	3,322.2	-

Өмнөх онтой харьцуулахад зөрчил, алдаа нэмэгдсэн нь хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, өр төлбөрийг илүү илэрхийлсэн, хөрөнгийг ангилал хооронд зөрүүтэй бүртгэсэн зөрчил байна. Энэ нь хууль зөрчих, хариуцлага, хяналтын тогтолцоог алдагдуулах эрсдэлийг бий болгож байна.

### **Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил**

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахтай холбоотой дараах алдаа гарсныг залрууллаа. Үүнд:

- **Баяндэлгэр ОНХС-ийн 754.1 сая, Засаг дарга дансны хөрөнгө оруулалтын зардлын 7,588.9 сая нийт 8,343.0 сая төгрөгийн зардлыг үр дүнгийн тайланд илүү илэрхийлснийг дахин тулгалт хийж алдааг залруулсан.**

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:**

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд Баруун-Урт сумын төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын 11,505.7 сая төгрөгийн хөрөнгийг Дөрвөлж ОНӨҮГ-т бүртгэх шийдвэр гарсан. Тайлант онд өмчит байгууллага 11,397.1 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг ангилж бүртгэлгүй, нийт дүнгээр үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Мөн ногоон байгууламж буюу зүлэг, бут тарих ажлыг дутуу хийж гүйцэтгэсэн, жигдрүүлэх сангийн насос, зөөврийн компьютер, жингийн тухай зэрэг 108.6 сая төгрөгийн хөрөнгийг авлагаар бүртгэж, тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийн мэдээлэл зөрүүтэй, бодит байдлыг гажуудуулан тусгагдах нөхцөлийг бүрдүүлжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төслийн хүрээнд бий болсон 11.505.7 сая төгрөгийн хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг

баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа зэрэг баримт материалд тулгуурлан Дөрвөлж ОНӨҮГ-т хүлээлгэн өгч, бүртгэх ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл**

Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,705.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 2,344.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. Залруулаагүй 3,360.6 сая төгрөгийн 133 алдаа зөрчлийн 62.3 сая төгрөгийн 20 зөрчилд төлбөрийн акт, 2,386.1 сая төгрөгийн зөрчил арилгах 41 албан шаардлага өгч, 6 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 886.8 сая төгрөгийн зөрчилд 51 зөвлөмж өгсөн.

Жилийн эцсийн байдлаар 27.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 123.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.

*Хүснэгт 15. 2024 оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн үлдэгдэл /сая төгрөгөөр/*

№	Аудитын шийдвэр	Хариуцлагын хэлбэр	Тоо	Дүн
А	Б	1	2	3
1	Албан шаардлага	ОНӨААТҮГ	1	123.3
2	Төлбөрийн акт	ТШЗ	1	27.8
3	Зөвлөмж	ТЕЗ	3	0
	Нийт дүн		5	151.1

Төлбөрийн актаар тогтоогдсон 27.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газар, албан шаардлагаар тогтоогдсон 123.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй Дөрвөлж ОНӨААТҮГ, мөн Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгдсэн тайланд өгсөн нийт 3 зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

## **5. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд Сангийн яам болон Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 3.4 сая ам.долларын дамжуулан зээлдүүлэх гэрээний хэрэгжилттэй холбоотой дараах нөхцөл байдал илэрлээ.

Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийн графикаар 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үндсэн зээлийн төлбөр 847.9 сая төгрөг, хүүгийн төлбөр 1,753.8 сая төгрөг, нийт 2,601.7 сая төгрөг төлөгдөхөөр байхад жилийн эцсийн байдлаар зээлдүүлэгчийг төлөөлөн Сангийн яам, зээлдэгчийг төлөөлөн Сүхбаатар аймгийн Засаг дарга нар өр төлбөрийн үлдэгдэлгүй тухай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Мөн гэрээнд төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги тооцохоор тусгасан байна.

Дээрх нөхцөл байдал нь Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдах урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан хүүгийн өглөг, болзошгүй алданги, санхүүгийн зардал болон холбогдох тайлбар тодруулгын бүрэн байдал, үнэлгээ, үнэн зөв байдалд материаллаг алдаа байж болзошгүй эрсдэлийг үүсгэж байна гэж үзэхээр байна. Иймд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад уг асуудлыг эрсдэлийн үнэлгээнд тусган авч үзэж, шаардлагатай нэмэлт горим сорил хэрэгжүүлэх нөхцөл байдал үүссэнийг толилуулж байна.

## **6. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **6.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ**

1. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 8,700.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,909.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, үлдсэн зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага, хариуцлага тооцуулах санал болон зөвлөмж хүргүүлсэн байна.
2. Илэрсэн алдаа, зөрчил нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын бүртгэл, ангилал, баталгаажуулалт болон төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв, иж бүрэн, бодитой байх зарчимд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Тухайлбал, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй ажил гүйлгээ бүртгэсэн, хөрөнгө, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлэлт, анхан шатны баримтаар бүрэн баталгаажуулаагүй, ОНХС болон ОНӨААТҮГ-ын хөрөнгийн бүртгэл, тайлагналын хяналт хангалтгүй зэрэг зөрчил давтагдсан байна.
4. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгө тус бүрийн задаргаа, улсын комиссын акт, санхүүжилт болон хүлээлцсэн баримтын бүрдлийг бүрэн хангаагүй нь хөрөнгийн ангилал, авлага, өглөгийн мэдээлэл бодит байдлаас зөрөх эрсдэлийг нэмэгдүүлсэн байна. Мөн дамжуулан

зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийн график, хүү, алданги, валютын ханшийн зөрүүтэй холбоотой өр төлбөрийг удирдах хяналт хангалтгүй байгаа нь орон нутгийн төсөвт санхүүгийн дарамт үүсгэх эрсдэлтэй байна.

5. Цаашид төсвийн сахилга, бүртгэл тайлагналын үнэн зөв байдал, худалдан авах ажиллагааны хууль ёсны хэрэгжилт, хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын түвшинд нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө баталж, Санхүү, төрийн сангийн хэлтсээр мэргэжил арга зүйн хяналт, дотоод аудитын нэгжээр эрсдэлд суурилсан хяналт-шалгалт, хэрэгжилтийн мониторинг тогтмол хийлгэх шаардлагатай байна.

## 6.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

### СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-Д

1. МОН-3713 төслийн хүрээнд бий болсон 11,505.7 сая төгрөгийн хөрөнгийг Дөрвөлж ОНӨҮГ-т бүртгэсэн асуудлыг хөрөнгө тус бүрээр нь задалж, холбогдох баримт материалд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүрэн, үнэн зөв бүртгэх шаардлагатай. Иймд байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилтийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт болон хөрөнгийн задаргааг нотлох бусад материалыг төсөл хэрэгжүүлэгч нэгж, холбогдох дээд шатны байгууллагаас албан ёсоор гаргуулан авах ажлын зохион байгуулж, зохих журмын дагуу бүртгэх арга хэмжээ авахыг зөвлөж байна.

### СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА-Д:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхээс өмнө хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардал, ОНХС, төсөл/сан, ОНӨААТҮГ-ын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт, анхан шатны баримт, дэд тайлантай тулгах “хаалтын шалгах хуудас”-ыг бүх байгууллагад мөрдүүлэх.
2. **Бүртгэлийн алдааг бууруулах арга зүй:** 2,909.3 сая төгрөгийн залруулсан алдааны төрлөөр сургалтын сэдэв гаргаж, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын журам, дансны жишиг жагсаалтын хэрэглээг байгууллага бүрийн нягтлан бодогчдод тайлбарлан мөрдүүлэх.
3. **Өр төлбөр, авлагын баталгаажуулалт:** Дамжуулан зээл, төсөл/сангийн авлага, ХХС-ийн зээл, ОНӨААТҮГ-ын өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, насжилт, эргэн төлөлт, эрсдэлийн ангилалтай бүртгэл хөтлөх чиглэл өгч, бодлого, арга зүйгээр хангаж ажиллах

### САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА-Д

1. **Эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргах:** 2026 оны дотоод аудитын төлөвлөгөөнд мөнгөн хөрөнгө, ОНХС, ХХС, худалдан авах ажиллагаа, хөрөнгө, өр төлбөр, дамжуулан зээлийн эрсдэлийг өндөр ач холбогдолтой сэдвээр тусгах.


**2. Аудитын шийдвэрийн мөрөөр хяналт тавих:** Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг улирал тутам баталгаажуулж, хугацаа хэтэрсэн, нотлох баримтгүй, чанаргүй биелэлтийг Засаг дарга болон холбогдох зөвлөлд танилцуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 02-ны дотор багтаан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

#### **Үндэсний аудитын газарт санал:**

**САНАЛ 1.** Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн Баруун-Урт сумын төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хөрөнгийг Дөрвөлж ОНӨҮГ-т бүртгэх, хүлээлгэн өгөх, тооцоо нийлэх ажиллагаа бүрэн хэрэгжээгүй, зарим ажил дутуу гүйцэтгэсэн, зарим хөрөнгө дутуу нийлүүлсэн, авлага өглөгийн мэдээлэл зөрүүтэй тусгагдсан нөхцөл байдал илэрч байгаа нь төслийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн ашиглалт, санхүүгийн тайлагналын бодит байдалд эрсдэл үүсгэж болзошгүй байна. Иймд уг төслийн гүйцэтгэл, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийх асуудлыг Үндэсний аудитын газрын сэдэв сонголтод тусгуулан авч үзэх нь зүйтэй гэж санал болгож байна.

#### **6.3 Холбогдох байгууллагын санал:**





МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518585  
Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn  
Цахим хуудас: www.sukhbaatar.gov.mn

2026.04.20 № 01/530

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлбар хүргүүлэх тухай

Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Тайланд тусгагдсан аудитын илрүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллана.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн ихэнх нь байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлага, сахилга сул, мэдлэг чадвар дутмаг байгаагаас шалтгаалсан асуудлууд байна гэж үзэж байна.

2026 онд санхүүгийн ажилтнууд мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд анхаарч 4 томоохон сургалтыг төлөвлөөд байгаа бөгөөд санхүүгийн сахилга, хариуцлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа сайжруулан ажиллах болно.

М.ИДЭРБАТ

**6.4 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:**

Шалгагдагч байгууллага тайлангийн төсөлтэй танилцаж, саналын зөрүүтэй санал ирүүлээгүй тул тайлбар гаргаагүй болно.

**6.5 Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:**



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/175

Баруун-Урт сум

Аудитын тайланг баталгаажуулах  
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Золзаяа)-т үүрэг болгосугай.

3.Аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоног, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Мөнхзаяа), Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга (Т.Цэрэгбаяр) нарт хариуцуулсугай.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Ө.Золзаяа), аудитор (Б.Мөнхбамбар), аудитор (О.Барчидгүнсэн) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\1. А тушаал-3 2025 хянуулах.docx

2226010155